



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

┌ Журам шинэчлэн батлах тухай ┐

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны жил бүрийн орлогод тооцох хүүгийн хэмжээг баталсан журмын дагуу тооцон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж мөрдөхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2007 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Журам батлах тухай” 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Р.Отгонжаргал/-нд даалгасугай.

ДАРГА  С.ЧИНЗОРИГ



Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

1116125031-5284708

ДААТГУУЛАГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ОРЛОГОД ТООЦОХ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ЖУРАМ

1. Энэхүү журмыг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээлгэсэн 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн даатгуулагчдын нэрийн дансанд бүртгэсэн орлогод жил бүр тооцох хүү (цаашид “Нэрийн дансанд тооцох хүү” гэнэ)-гийн хэмжээг тогтооход баримтална.

2. Нэрийн дансанд тооцох хүүгийн хэмжээ нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 3 жилийн дундаж хөдөлмөрийн хөлсний дундаж өсөлттэй тэнцүү байна.

3. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсийг дараах томъёог ашиглан тооцно. Үүнд:

$$\bar{x} = \frac{\sum_{i=1}^N w_i x_i}{N}$$

\bar{x} - Жигнэсэн дундаж хөдөлмөрийн хөлсний хэмжээ /төгрөгөөр/

w_i - Даатгуулагчдын тоо

x_i - Хөдөлмөрийн хөлсний хэмжээ /төгрөгөөр/

N - Нийт даатгуулагчдын тоо

Санамж 1: Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсийг тооцохдоо зөвхөн албан журмын даатгуулагчдын шимтгэл төлсөн хөдөлмөрийн хөлсийг үндэслэх бөгөөд цэргийн алба хаагчид, сайн дурын даатгуулагчдын хөдөлмөрийн хөлс болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон ажил олгогчийн шимтгэл төлсөнийг тус тус тооцохгүй.

4. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлтийн хувийг тооцохдоо геометр дунджийн дараах томъёог хэрэглэнэ. Үүнд:

$$K_p = \sqrt[n]{\frac{\bar{x}_n}{\bar{x}_0}}$$

K_p – Дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлтийн хувь

\bar{x}_n – Сүүлийн жилийн дундаж хөдөлмөрийн хөлс

\bar{x}_0 – Эхний жилийн дундаж хөдөлмөрийн хөлс

Санамж 2: Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсний өсөлтийн дундаж хувийг тооцохдоо уг хувийг тооцож буй жилийн урд оны дундаж хөдөлмөрийн хөлсийг түүний өмнөх 3 дахь оны дундаж хөдөлмөрийн хөлсөнд харьцуулсан харьцаанаас геометр дунджийг гаргах замаар тодорхойлно.

Жишээ нь: 2018 оны нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтооход баримтлах дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлтийн хувийг дор дурдсанаар тооцно. Үүнд:

$$\sqrt[3]{\frac{2017 \text{ оны дундаж хөдөлмөрийн хөлс}}{2014 \text{ оны дундаж хөдөлмөрийн хөлс}}}$$

5. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь даатгуулагчийн нэрийн дансанд тооцох хүүгийн хэмжээг энэ журмын дагуу тогтоож, Үндэсний статистикийн хорооноос санал авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн, жил бүрийн дараа оны нэгдүгээр улиралд багтаан батлуулж мөрдөнө.

---oOo---